

## **ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНТ ХОВД АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ТҮҮХ**

БНМАУ-н засгийн газрын 1926 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 5 дугаар хурлаас Алтанбулаг, Жаргалант, Улиастай хотууд, Цэцэрлэг мандал, Хан хэнтий аймгуудад дарга бичээч тус бүр 1, цагдаа 10-аад орон тоотой “Цагдан сэргийлэх хороо” байгуулж төсвийг нь баталжээ. Дээр нэр дурдагдсан Жаргалант хот нь одоогийн Ховд аймгийн төв Ховт хот бөгөөд 1762 онд суурь нь тавигдаж Манжийн амбан сайдын газар, Орос улсын худалдааны консулын газар байрлаж байсан баруун хязгаарын томоохон суурин газар байв. БНМАУ-н Засгийн газрын 1925 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 32 дугаар тогтоолоор Ховд хотыг Жаргалант хот хэмээн нэрлэх болжээ. 1961 онд буцаан Ховд хот гэж нэрлэжээ. Ийнхүү Ховд аймагт Цагдан сэргийлэх байгууллага байгуулагджээ.

1938 онд Цагдан сэргийлэх хороог өргөтгөн Цагдан сэргийлэх анги байгуулжээ. Тус анги нь дарга, төлөөлөгч, бичээч, галч, зарлага тус бүр 1, сэргийлэгч 8 бүгд 13 орон тоотой ажиллах болжээ. Улсын цагдан сэргийлэх газрын уурын тэрэгний хэлтэст ахлах байцаагчаар ажиллаж байсан Нарангийн Жасранг томилсон боловч ирж ажиллаагүй харин Ховд аймгийн Буянт сумын харьяат Бумболын Жадамбаа даргаар ажиллажээ. Төлөөлөгчөөр Лувсанцэрэн, сэргийлэгчээр Буянт сумын харьяат Г.Готов, Ж.Пэлжээ, Осор, Баатар, Балзан, Чойжамц, Баянмөнх, Дамдинсүрэн нарын хүмүүс ажиллажээ.

1990 оны 4 дүгээр сарын 18-нд НАХЯ-ыг татан буулгажээ. БНМАУ-н Сайд нарын зөвлөлийн 1990 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 192 дугаар тогтоолоор УЦСЕГ-ыг бие даасан газар болгон өөрчилсөнөөр аймгуудад Цагдан сэргийлэх хэлтэс ажиллах болжээ.

Хүн амын нягтаршил ихтэй, нутаг дэвсгэрээр нь хилийн 2 боомт нээгдэн ажиллах болсон зэрэг байдлыг харгалзан Булган суманд 1990 онд Цагдаагийн хэсэг байгуулжээ. Цагдаагийн газрын даргын 2008 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 651 тоот тушаалаар Булган сум дахь Цагдаагийн тасаг нь аймгийн баруун 6 сум буюу Булган, Үенч, Алтай, Мөст, Мөнххайрхан сумдыг хариуцан ажиллах болжээ. цагдаагийн ерөнхий газрын даргын 2013 онд 7 дугаар сарын 1-ний өдрийн 265 дугаар тогтоолоор Булган сум дахь Цагдаагийн тасгийг өргөтгөн Цагдаагийн хэлтэс болгон ажиллуулж даргаар нь Лхагвадорж томилогджээ.

1997 оны 8 дугаар сард одоогийн байгаа байрандаа оров. 1997-1998 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Цагдан хорих, эрүүлжүүлэх баривчлах байрны барилга баригджээ. Хугацаанд аж ахуйн аргаар 10 машины граж, аж ахуйн склад барьжээ.

Цагдан сэргийлэх анги нь 1990 оны 03 дугаар сарын 31-нд “Цагдан сэргийлэх хэлтэс”, мөн оны 10 дугаар сарын 26-нд “Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтэс” гэж нэрлэгдэх болсон байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2005 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн тушаалаар Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийг газар болгон өргөтгөжээ.

